## ИНТЕРНЭТ БОЛОН УТАСНЫ СҮЛЖЭЭГҮЙ ҮЕД БАРИМТ ҮҮСГЭХ ЗААВАРЧИЛГАА

**ХЭРЭГЛЭЭ:**

Сүлжээ ороогүй газар үйлдвэрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч интернэт болон утасны сүлжээгүй үед баримт үүсгэх боломжтой.

**АНХААРАХ:**

50 ширхэг баримтаас илүү баримт үүсгэх боломжгүй. Нэг удаагийн баримтын дүн 3 сая төгрөгөөс давахгүй байх.

### АЛХАМ 1

Гар утасны ebarimt аппликейшний нэвтрэх цонх дээр очиж дэлгэцийг баруунаас зүүн тийш гүйлгэнэ.



## АЛХАМ 2

**Төлөх дүн** оруулах хэсэгт худалдан авалтын дүн, бүтээгдэхүүний хэмжээг оруулан **БАРИМТ АВАХ** товч дарахад гарч ирэх **“Гүйлгээ баталгаажуулах”** цонхны **БАРИМТ ҮҮСГЭХ** товч дарна. Хэрвээ төлөх дүнг буруу оруулсан бол **ДҮН ЗАСВАРЛАХ** товч даран засах боломжтой.




## АЛХАМ 3

**Байгууллага дээр авах** товчийг дарж, **Гүйлгээний тайлбарт** утга оруулан **ХАДГАЛАХ** товч дарна.








# ИНТЕРНЭТ БОЛОН УТАСНЫ СҮЛЖЭЭГҮЙ ҮЕД БАРИМТ ҮҮСГЭХ ИЛГЭЭХ

## АЛХАМ 1

Сүлжээтэй газар итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрийн ebarimt аппликейшн рүү нэвтэрч орсны дараа **“Татвар”** цэсийг дарахад зурагт үзүүлсний дагуу **оффлайн** баримтууд харагдана.




## АЛХАМ 2

Үүссэн төлбөрийн баримтыг Байгууллага дээр авах товчийг дарж, байгууллагын регистрийн дугаарыг оруулан төлбөрийн баримтыг зурагт үзүүлсний дагуу үүсгэх шаардлагатай. (Хувь хүн дээр үүссэн төлбөрийн баримт нь эцсийн хэрэглээнд гарах тул заавал байгууллага дээр авах товчийг дарах шаардлагатайг анхаарна уу.)






**АНХААРАХ:**
*Тухайн төлбөрийн баримтыг малчин баталгаажуулалт хийх шаардлагатай.*

## ТӨЛБӨРИЙН БАРИМТЫГ ХЭРХЭН БАТАЛГААЖУУЛАХ ВЭ?

Үйлдвэрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч үүсгэсэн төлбөрийн баримтыг малчид баталгаажуулалт хийх шаардлагатай. Ингэснээр та өөрийн борлуулалтын хэмжээнд хяналт тавих болон урамшууллын дүнг мэдэх боломжтой юм. Баталгаажуулалтыг гар утасны ebarimt аппликейшн болон компьютероор хандалт хийж баталгаажуулах боломжтой.

## ГАР УТАСНЫ EBARIMT АППЛИКЕЙШНЭЭР БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ



Өөрийн ebarimt аппликейшн рүү хандалт хийж нэвтэрч орсны дараа Татвар цэсийг дарна. Татвар цэсийн хамгийн сүүлийн хуудас буюу **Төлбөрийн баримт** гэсэн хуудсыг гараараа гүйлгэж гаргана.